



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/296

Есөнбулаг сум

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.11 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Чинзориг	(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд:	Б.Содмаа	(Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн дарга)
	Г.Билэгсайхан	(Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
	Г.Олонбаатар	(Байгаль орчны газрын биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Батмагнай	(Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн удирдамжийг батлуулан, дуудлага худалдааг хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025 A-4

8200010790